



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 10/63

Чингис хот

“Эрх зүйн хөтөч”-ийн булан тохижуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн зөвлөгөө мэдээлэл, сурталчилгааны "e-khutuch" портал цахим хуудсыг сумдад ашиглалтад оруулах, "Эрх зүйн хөтөч"-ийн буланг тохижуулах зардалд 9.990.000 /есөн сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг сайтар зохион байгуулахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Л.Бат-Октябрь/-т, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010178

Аймгийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 10 өдрийн 463
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Сумдад эрх зүйн хөтчийн буланг тохижуулах	9	1.000.000	9.000.000
2	Сумдад эрх зүйн хөтчийн буланг тохижуулах	1	990.000	990.000
Нийт				9.990.000